

Хүүхдэд зориулсан Библи
танилцуулж байна

Баяртай
Фараон!



Зохиогч: Edward Hughes

Зураглаач: Janie Forest; Alastair Paterson

Найруулсан: Lyn Doerksen

Орчуулсан: Damdin Norolsuren

Бүтээсэн: Bible for Children
www.M1914.org

©2021 Bible for Children, Inc.

**Зөвшөөрөл: Та энэ бүтээлийг хувилах хуулах
эрхтэй харин худалдахыг хориглоно.**





**Фараон ихэд ууртай
байв! Бурхан түүнд
Мосегоор дамжуулан
Израил боолуудыг
чөлөөлж Египетээс
явуулахыг
тушаажээ.**



**Тэр татгалзав.
Фараон "Тэдний
ажлыг нэм" гэж
ажлын дарга нарт
тушаав. Бүх зүйл
Израилчуудад
муугаар эргэв.**



"Тоосго хийхэд ордог сүрлийг та нар өөрсдөө явж цуглуул бид та нарт сүрэл өгөхгүй гэхдээ тоосгыг урьдын адил тоогоор хийх



ёстой" Энэ бол Фараоны гаргасан шинэ тушаал байлаа.



Ажлын дарга
нар зарим Еврей
боолуудыг тоосгоо
хийх ёстой

ХЭМЖЭЭНЭЭСЭЭ бага ...



... ХИЙЛЭЭ ХЭМЭЭН
ташуурдаж байв
учир нь сүрэл түүж
ирээд тоосгоо

хийхэд цаг

хүрэлцэхгүй
байлаа.





**Хүмүүс
зовсноосоо
болоод Мосе
Аарон нарт
ГОМДОЛЛОВ.**





**Мосе
залбирах
газар олоод
"ЭЗЭН МИНЬ
ЭЭ" ХЭМЭЭН
хашхирав.**

**"Та өөрийн
хүмүүсээ
аварсангүй"
ГЭЛЭЭ.**





**Бурхан
"Би бол
Эзэн, Би та
нарыг гаргах
болно" гэж
хариулав.**



Тэгээд Бурхан
Мосе Аарон
хоёрыг дахин
Фараонруу
ИЛГЭЭВ.



Хүчит захирагч
Бурханы
ТЭМДГИЙГ
ҮЗҮҮЛЭХИЙГ
ХҮСЭХЭД

Аарон таягаа
могой болгон
хувиргав.





**Фараон "Манай
илбэчдийг дууд"
хэмээв. Египетийн
илбэчид таягаа
доош хаяхад таягууд
нь бас могой
болон хувирав.**





**Харин
Аароний
таяг бусад
таягуудыг
залгичхав.**





Гэсэн хэдий
ч Фараон
хүмүүсийг
явуулахаас
татгалзсаар
л байв.



Дараа өдрийн өглөө Мосе Аарон хоёр
Фараонтой голын эрэг дээр уулзав.



Аарон таягаараа голын усыг цохиход
голын ус цус болон хувирав.
Загаснууд үхэв!



Хүмүүс уснаас ууж чадахгүй болов!



**Гэвч Фараон зүрхээ улам хатууруулав.
Тэр Израильчуудыг Египетээс
явуулсангүй.**



Дахин Мосе Фараонд Бурханы
ард түмнийг явуул

ГЭЖ ХЭЛЭВ.

Фараон дахин
татгалзлаа.

Бурхан тэдэнд
өөр гамшиг
илгээв. Бүх
Египет
мэлхийгээр
дүүрчээ.



**Бүх гэр, бүх өрөө, бүүр зууханд
нь хүртэл мэлхийнүүд**

үсэрч байв.

Фараон “Би

танай

хүмүүсийг

явуулах болно.

Мэлхийнүүдийг

холдуул гэж

миний төлөө

Бурхандаа ...




... залбирч өгнө үү” гэж Мосегоос
гуйжээ. Харин


мэлхийнүүд
алга болсны
дараа Фараон
бодлоо
өөрчилж
боолуудыг
явуулсангүй.



**Тэгэхэд Бурхан тэдэнрүү бөөн бөөс
ИЛГЭЭВ.**



**Хүн бүр бөөсөнд хазуулснаасаа
болоод бүх бие нь загатнаж байсан ч
Фараон Бурханыг дагасангүй.**






Үүний
дараа


**Бурхан асар олон
ялааг тэдэнрүү
илгээв. Бурхан мөн
Египетийн мал
сүргийг үхүүлэх
тахал илгээв.**





**Бурхан бас хүн малд
нь идээт яр илгээв.
Хүмүүс ярнаас болж
маш ихээр өвдөн
шаналж байв.**





**Гэвч Фараон
Бурханыг
эсэргүүцсээр
л байв.**





Үүний
дараа
Бурхан
царцааны
сүргийг
ИЛГЭЭВ.





Царцаан
сүрэг бүх
ногоон
ургамлыг
идэж
устгажээ.







Бурхан гурван өдрийн
турш харанхуй болгов.
Гэвч зөрүүд Фараон
Израилчүүдийг
тавьж явуулсангүй.



**Бурхан би
одоо бас
дахин нэг
гамшиг
илгээх
болно гэж
анхааруулав.
"Энэ шөнө
малын анхны
төл бүх хүний ууган
хөвгүүд нь үхэх болно" гэв.**



**Бурхан Израилийн
гэрүүд хэрэв
тэд үүдэн
дээрээ
хурганы
цусаар
тэмдэг
тавьбал
тэдний ууган
хөвгүүд аврагдах
болно гэв.**





**Шөнө дунд
Египет даяараа
маш ихээр уйлан
гашуудав.**





**Үхэл тэднийг
дайрчээ. Гэр
болгоноос нэг
хүн үхсэн байв.**





Фараон "Явцгаа"
гэж Мосегоос
гуйв. "Явж
Эзэн Бурхандаа
үйлчил" гэв.





**Бурханы хүмүүс
хурдан гэгч нь
Египетийн
хилээр гарлаа.**





**Бурхан Мосед Дээгүүр
өнгөрсөн тэр шөнийг
дурсан санаж яв учир нь
Бурханы тэнгэр элч ...**






**... Израилийн гэрийн
дээгүүр өнгөрч харин
Фараоны болон тэдний хүмүүсийг
үхэл дайрсан юм гэв.**





**Дөрвөн зуун гучин
жилийн дараа Бурханы
ард түмэн Египетээс ингэж
чөлөөлөгдсөн юм.**





**Бурхан тэднийг
өдөр нь үүлэн баганаар
сүүдэрлэж, шөнө нь галан баганаар
гэрэлтүүлэн дагуулж байлаа.**





**Гэвч Фараон
Израилчүүдта
й дуусгавар
болоогүй
байлаа.**





**Тэр Бурханыг
дахин мартав.
Тэр дахин
бодлоо
өөрчлөв.**





**Тэрээр цэргээ
цуглуулан
боолуудын араас
хөөв. Удалгүй
тэр тэднийг
хадан цохио
тэнгис хоёрын
голд гүйцэв.**



**Моcе "Эзэн та нартай тулалдах
болно" гээд усны захад очоод
хоёр гараа өргөв.**





**Агуу
гайхамшиг
болов.**



**Бурхан
ТЭНГИСИЙН
УСЫГ хувааж
зам нээв.**



**Хүмүүс
түүгээр
аюулгүй
гаталж
гарав.**



Харин энэ үед Фараоны цэргүүд тэдний
араас Улаан тэнгис уруу хурдлан
оров. "Одоо та нар баригдсан"
гэж цэргүүд боджээ.



**Гэвч Бурхан усыг хаав. Египетийн
цэргүүд живжээ. Ингээд Фараон
Израилийн Бурхан л бүгдийн
Эзэн гэдгийг ойлгожээ.**



Баяртай Фараон!

Бурханы үг Библиээс авсан түүх

Египетээс гарсан нь 4-15

"Таны үгсийн тунхаглал гэгээрүүлдэг."

Дуулал 119:130



Төгсөв



Библийн түүх нь гайхамшигт Бурхан биднийг бүтээсэн бөгөөд таныг өөрийгөө мэдээсэй гэж хүсдэг тухай бидэнд хэлдэг.

Бурхны гэм гэж нэрлэдэг муу зүйлийг бид үргэлж хийдгийг Бурхан сайн мэднэ. Гэмийн шийтгэл нь үхэл боловч Бурхан танд маш их хайртай учир Тэрээр цорын ганц хүү Есүсийг таны гэмийн өмнөөс шийтгүүлэн загалмайд цовдлогдон үхэхийг зөвшөөрөн энэ дэлхийд илгээсэн юм. Тэгээд Есүс дахин амилж тэнгэр дэх гэртээ буцсан! Хэрвээ та Есүст итгэж түүнээс гэмийнхээ төлөө уучлал гуйвал Тэрээр таныг уучлах болно! Тэрээр таньруу ирэх бөгөөд тантай хамт байх болно мөн та түүнтэй мөнхөд хамт амьдрах болно.



Хэрвээ та энэ үнэнд итгэж
байвал Бурханд хандан ийнхүү хэлээрэй:
Эрхэм Есүсээ, Би таныг Бурхан гэдэгт болон
миний гэмийн төлөө үхсэн гэдэгт мөн одоо та
амьд гэдэгт итгэж байна. Миний амьдралд орж
ирээд миний гэмийг уучлаач, тэгээд Би одооноос
эхлээд шинэ амьдралаар амьдарч нэг өдөр
тантай хамт мөнхөд байхаар явах болно. Танд
дуулгавартай байж таны хүүхэд шиг таны төлөө
амьдрахад туслаач. Амен.

Библи уншиж өдөр бүр Бурхантай
ярилцаарай! Иохан 3:16

